



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**



**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
MNS 6541:2015**

Салбарын нэр: Барилга

Мэргэжлийн нэр: Барилгын засал чимэглэлчин

БОУСА-ийн хөтөлбөрийн индекс:

Монголын мэргэшлийн үндэсний хүрээний түвшин: VI

**УЛААНБААТАР ХОТ
2019 он**

Боловсруулсан багийн гишүүд:

- | | | |
|---|--------------|---|
| 1 | О.Сайнгэрэл | Дундговь аймаг дахь МСҮТ, Барилгын засал чимэглэлчин мэргэжлийн багш |
| 2 | Э.Сүхбат | Төв аймгийн Эрдэнэ суман дахь МСҮТ, Барилгын засал чимэглэлчин мэргэжлийн багш |
| 3 | Д.Одонтуяа | Улаанбаатар хотын БПК, Барилгын засал чимэглэлчин мэргэжлийн багш |
| 4 | Л.Энхжаргал | Улаанбаатар хотын Барилгын бүтээцийн МСҮТ, Барилгын засал чимэглэлчин мэргэжлийн багш |
| 5 | Ш.Алтантуяа | Орхон аймаг дахь МСҮТ, Барилгын засал чимэглэлчин мэргэжлийн багш |
| 6 | А.Гэрэлмаа | Дорнод аймаг дахь МСҮТ, Сантехник, гагнуурын мэргэжлийн багш |
| 7 | Б.Гэрэлмаа | Боловсролын хүрээлэн, МБС-ын Хөтөлбөр хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан |
| 8 | Ш.Алтанцэцэг | “Индустр” ХХК-ийн Засал чимэглэлчин |
| 9 | Д.Дэнсмаа | “Бум Номин” ХХК-ийн Инженер |

Хянасан: ХНХЯ болон барилгын салбарын экспертүүдийн төлөөлөл

- | | | |
|---|--------------|---|
| 1 | Д.Адилбиш | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн |
| 2 | М.Батбаатар | Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч |
| 3 | Б.Сүүндэлгэр | “Сүүн мандал” ХХК-ийн Захирал |
| 4 | Ц.Сүхбаатар | “СНС” ХХК-ийн Ерөнхий инженер |
| 5 | Б.Ганбат | “Гексаэдр” ХХК-ийн Ерөнхий инженер |
| 6 | Г.Батсайхан | Өргөн Тээвэрлэх Машин Төхөөрөмж Үндэсний Холбооны Барилгын багш |

ДАКУМ чиглүүлэгч:

- | | | |
|---|--------------|-------------------------|
| 1 | П.Оюунсайхан | Барилгын зөвлөх инженер |
|---|--------------|-------------------------|

Зөвлөхүүд :

- | | | |
|---|-------------|---|
| 1 | Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх |
| 2 | Ц.Ганчимэг | АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ЧССҮ-ний мэргэжилтэн |
| 3 | Г.Батчимэг | ЧССҮ-ний Зөвлөх |

	АГУУЛГА	Хуудас
	Өмнөх үг	4
1	Зорилго	5
2	Хамрах хүрээ	5
3	Норматив ишлэл	5
4	Нэр томъёо, тодорхойлолт	5
5	Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавигдах шаардлага	8
	5.1 Сургалтын агуулга	8
	5.2 Сургалтын хугацаа	31
6	Суралцах хэлбэр	31
7	Сургалтын үнэлгээнд тавигдах шаардлага	32
8	Барилгын засал чимэглэлчин мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлага	32
9	Багшид тавигдах шаардлага	33
10	Сургалтын орчинд тавигдах шаардлага	33
11	Сургалтын тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн жагсаалт	34
12	Номын сан, мэдээллийн хангамжид тавигдах шаардлага	44
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	44
14	Стандартад хэрэглэсэн товчилсон үгийн тайлбар	44

ӨМНӨХ ҮГ

Хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлээр Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлагыг боловсруулав.

Энэхүү “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”-ыг барилгын засал чимэглэлчид болон ажил олгогчид, чадамжид суурилсан сургалт, үнэлгээний олон улсын зөвлөх, үндэсний зөвлөх, салбарын багш нарын төлөөллийг оролцуулан ДАКУМ арга зүйгээр боловсруулсан ажил мэргэжлийн лавлахад үндэслэн ажилбар, үүрэг нэг бүрээр чадамжийн дүн шинжилгээ хийж боловсруулсан болно.

Мэргэжлийн боловсрол, сургалт нь төр, хувийн хэвшлийн бодит түншлэл, шинэ технологи, шилдэг сургалтын арга зүйд тулгуурлан хөгжиж, өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтнууд төрөн гарч, үйлдвэрлэгч, бүтээгч улс болж, хөгжих болтугай.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагыг хангахуйц, мэргэшлийн түвшний тогтолцоотой уялдсан уян хатан сургалтыг “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлээр зохион байгуулах мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, орчин, багшийн мэргэшил, үнэлгээнд тавигдах үндсэн шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандартыг “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлээр мэргэжлийн боловсрол, сургалт эрхлэн явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, судлаач, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаарх төрийн удирдлага, аргазүй, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад олон улсын болон үндэсний стандарт, баримт бичгийг иш татаж хэрэглэсэн болно. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1** MNS 1-1:2006 Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг
- 3.2** MNS 1-1:2006 Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг
- 3.3** MNS 5742:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага
- 3.4** MNS 5566:2005 Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
- 3.5** MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- 3.6** MNS 5869:2008 Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага
- 3.7** БНБД-II-66-88 “Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм”
- 3.8** БНБД 21-01-02 Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал
- 3.9** Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- 3.10** БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга
- 3.11** БНБД 31-03-03 Эрүүл ахуйн норматив
- 3.12** YAMAT-08 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
- 3.13** Ажил мэргэжлийн лавлах толь, Улаанбаатар, 2014
- 3.14** БНБД 31-10-05 “Заслын ажил”
- 3.15** БНБД 52-02-05 “Цутгамал бетон, төмөрбетон бүтэц”
- 3.16** БНБД 31-09-05 “Шалны ажил”

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1

албан боловсрол

боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг;

4.2

мэргэжил

тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

4.3

мэргэшил

тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг;

4.4

мэргэжлийн боловсрол

тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.5

техникийн боловсрол

техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.6

мэргэжлийн суурь чадвар

нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшлийг;

4.7

мэргэшлийн түвшин

ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг;

4.8

чадамжид суурилсан сургалт

мэргэжлийн боловсрол, сургалтаар ажлын байранд тухайн ажлыг ажил мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэхийн тулд эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох, төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт;

4.9

чадамжид суурилсан үнэлгээ

суралцагч ажил, үүргийг мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлэн зөв, нямбай хийж гүйцэтгэж байгаа эсэхийг чадамжийн нэгжийн хүрээнд боловсруулсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу нотолгоонд суурилан үнэлгээ хийж, баримтжуулах үйл явц;

4.10

чадамж

хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавигдах мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.11

чадамжийн нэгж

үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг гүйцэтгэлийн үнэлэмжийн хамгийн бага нэгж бөгөөд ихэвчлэн үр дүнгээр хэмжигддэг. Тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг;

4.12

чадамжийн элемент

чадамжийн нэгжийн дагуу гүйцэтгэх ёстой ажлын гол хэсгүүд буюу ажилбарыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол үе шатууд. Элементүүд нь тодорхой ажлыг гүйцэтгэхэд хэрэгцээтэй үйлдлүүдийг тодорхойлдог;

4.13

гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

чадамжийн нэгж болон элементүүдийг тавигдсан стандартын дагуу гүйцэтгэх шалгуур;

4.14

үнэлгээний төлөвлөгөө

зорилтот бүлгийг ямар чадамжийн нэгжийн шалгуур үзүүлэлтийн дагуу хэзээ, хаана, хэрхэн яаж үнэлэхийг төлөвлөсөн баримт бичиг;

4.15

чадамжийн нэгжийн үнэлгээ

тухайн хувь хүн чадамжийн стандартыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд нотлох материал, мэдээлэл цуглуулж холбогдох үнэлэлт, дүгнэлт гаргах үйл явц;

4.16

чадамжийн багц

ажилтан мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлж, хөдөлмөрийн чиг үүргийн чанартай гүйцэтгэлийг хангахад шаардагдах мэдлэг, чадвар, туршлага харилцааны багц;

4.17

багц цаг

дээд болон мэргэжлийн боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг.

5. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавих шаардлага

5.1 Сургалтын агуулга

5.1.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь “Барилгын засал чимэглэлчин” мэргэжилд хамаарах чадамжийн нэгжүүдээс бүрдэнэ. Чадамжийн нэгжийг “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлийн ажил мэргэжлийн тодорхойлолтод (лавлах) тусгагдсан мэргэжлийн үүрэг, ажилбаруудад тулгуурлан боловсруулсан болно.

5.1.2 Ажил мэргэжлийн үүрэг, ажилбаруудыг ДАКУМ (ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх) аргаар тодорхойлж, ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулсан.

5.1.3 Ажил мэргэжлийн дүн шинжилгээнээс “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлийн чадамжийн нэгжийн жагсаалтыг тодорхойлж гаргасан. Уг чадамжийн нэгжийн жагсаалтад ороогүй “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлийн ерөнхий суурь хэсэг болон мэргэжлийн үндсэн ойлголт, онолын мэдлэгийг багш сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

А хавсралт: А.1-р маягт

ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Сургалтын агуулга	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
1	Мэргэжлийн суурь	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах	
2		Заслын ажилд бэлтгэх	CF7123-20-01-401
3		Шавардлагын ажил хийх	CF 7123-20-02-401
4		Гадаргууд тэгшилгээ хийх	CF 7123-20-03-401
5		Бетон шалны ажил хийх	CF 7123-20-04-401
6		Будгийн ажил хийх	CF 7123-20-05-401
7		Цаасан өнгөлгөөний ажил хийх	CF 7123-20-06-401
8		Гоёлын хийцийн ажил хийх	CF 7123-20-07-401
9	Мэргэшүүлэх	Хавтанцар өнгөлгөөний ажил хийх	CF 7123-20-08-401
10		Чулуун өнгөлгөөний ажил хийх	CF 7123-20-09-401

5.1.4 “Барилгын засал чимэглэлчин” мэргэжил нь Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VI түвшинд хамаарах бөгөөд хамаарах чадамжийн нэгж бүрийг эзэмших шаардлагатай.

5.1.5 Энэхүү стандартын А хавсралт: А.1-р маягтад дурьдах шаардлагатай “Барилгын засал чимэглэлчин” мэргэжлийн Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VI түвшинд харгалзуулах чадамжийн нэгжүүд нь 5.1.3-т зааснаар,

гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь А хавсралт: А.3-р маягтад заасны дагуу тодорхойлогдоно.

5.1.6 Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн жагсаалтуудыг А хавсралт, А.2-р маягтын дагуу дараах байдлаар боловсруулсан.

5.1.7 Чадамжийн нэгж нь чадамжийн элементүүдээс бүрдэнэ. Чадамжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг А хавсралтын А.3-р маягтын дагуу боловсруулсан. (А хавсралтын А.2, А.3-р маягыг нэгтгэн чадамжийн нэгж бүрээр боловсруулсан.)

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах
Чадамжийн нэгжийн код:
<p>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</p> <p>Эзэмшвэл зохих мэдлэг</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журам, практик хэрэглээ • Хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, тэдгээрийн ашиглалт • ХАБЭА-н шаардлага, стандарт мөрдөх • Тайлагнах болон мэдээллэх • Аюул, эрсдэлийг тодорхойлж, хянах • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлтүүд • Байгууллагын аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам <p>Эзэмшвэл зохих ур чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Хувийн ариун цэврийг сахих • Аюул, эрсдэлийг тодорхойлж, хянах • Бусадтай харилцах • Мэдээлэл харилцааны бусад • Ажлын байрыг бэлтгэх • Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах • Онцгой байдлын үед авах арга хэмжээг хэрэгжүүлэх • Анхны тусламж үзүүлэх • Хувийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой бүрэн ашиглах • ХАБЭА-н шаардлага стандарт ажлын байранд бүрэн ашиглах • Хамтран ажиллагсад зөв мэдээлэл дамжуулах чадвар • Гадна дотны бүх харилцагчтайгаа хүндэтгэлтэй, зөв боловсон, шударга харилцах чадвар <p>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</p> <ul style="list-style-type: none"> • Аюулгүй байдлыг хангах • Эрүүл ахуйг хангах • Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших • Хувийн ариун цэврийг сахих • Суралцах соёл. • Хөдөлмөрийн сахилгатай • Нягт нямбай, цэвэрч • Мэргэжилдээ сонирхолтой • Идэвхи санаачлагатай • Хариуцлагатай • Хувийн зохион байгуулалттай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. ХАБЭА-н үндсэн ойлголт ба хууль эрх зүйн орчин	ГШҮ 1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн бүтэц, агуулгатай танилцах
	ГШҮ 1.2 ХАБЭА-д холбогдох эрх зүйн бусад баримт бичигтэй танилцах.
	ГШҮ 1.3 ХАБЭА-н тухай хууль тогтоомж болон бусад шаардлагыг зөрчих, түүний үр дагавартай танилцах.
	ГШҮ1.4. Хамгаалах техник, хувийн ба тусгай хамгаалах хэрэгсэлтэй танилцах
	ГШҮ1.5 ХАБЭА-н сургалт, зааварчилгаа, аюулгүйн тэмдэг тэмдэглэгээтэй танилцах
ЧЭ 2. Ажлын байрыг зөв зохион байгуулах	ГШҮ 2.1 Ажлын байран дахь осол, гал түймэр, онцгой байдлын үед сахих дүрэм журмыг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бодлогод уялдуулан дагаж мөрдөх.
	ГШҮ 2.2 Ажлын байрны шаардлага стандарт хангаж ажиллах
	ГШҮ 2.3 Аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах
ЧЭ 3. Ажлын байрны аюулыг илрүүлэх болон эрсдэлийн үнэлгээнд оролцох	ГШҮ 3.1 Ажлын байрны аюулыг тодорхойлох, тохиромжтой арга барил сонгоход оролцох
	ГШҮ 3.2 Аюулыг илрүүлж байгаа ажилтанг тусламж, мэдээллээр хангах
	ГШҮ 3.3 Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний тохиромжтой арга сонгоход оролцох
	ГШҮ 3.4 Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа ажилтанг тусламж, мэдээллээр хангах
ЧЭ 4. Хөдөлмөрийн, аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах	ГШҮ 4.1 Хувийн хамгаалах хэрэгслийг байгууллагын заавар чиглэл, дүрэм журамд нийцүүлэн ашиглах
	ГШҮ 4.2 Ажлын байранд тавигдах шаардлагын дагуу хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын хувийн хэргийг бөглөх
	ГШҮ 4.3 Онцгой байдалтай холбоотой дасгал, сургуулилтын үед баримтлах дүрэм журмыг байгууллагын тогтсон заавар чиглэл, дүрэм журамд нийцүүлэн зүй зохистой дагаж мөрдөх
ЧЭ 5. Шаардлагатай нөхцөлд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх	ГШҮ 5.1 Ажлын байран дахь яаралтай тусламжийн үед туслалцаа үзүүлэхтэй холбоотой дүрэм журмыг байгууллагын тогтсон дэг журамд нийцүүлэн тодорхойлох
	ГШҮ 5.2 Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх арга барил, аргачлалыг судлах.
	ГШҮ 5.3 Дасгал сургуулилтын явцад зөв аргаар цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Заслын ажилд бэлтгэх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журам, практик хэрэглээ• Хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, тэдгээрийн ашиглалт• ХАБЭА-н шаардлага, стандарт мөрдөх• Ажлын даалгавартай танилцах• Багаж хэрэгслийн ашиглах• Тоног төхөөрөмжийн ашиглалт зориулалт• Материалын орц норм• Барилгын ажлын үндэс• Ажлын графикт төлөвлөгөө боловсруулалт• Ажлын үргэлжлэх хугацаа ажиллах хүчинг тогтоох• Талбайн хашилт хаалт хамгаалалт• Шат вандангийн төрлүүд Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Хувийн ариун цэврийг сахих• Аюул, эрсдэлийг тодорхойлж, хянах• Бусадтай харилцах• Ажлын байрыг бэлтгэх• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах• Талбайн зохион байгуулалт• Материалыг сонгож ашиглах• Ажлын зураг унших• Ажлын талбайд хэмжилт хийх• Ажлын төлөвлөгөө боловсруулах• Материалын орц нормын тооцоо гаргах• Төрөл бүрийн шат вандангийн угсралт суурилуулалтыг эзэмших• Анхан шатны тусламж үзүүлэх• Хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Аюулгүй байдлыг хангах• Эрүүл ахуйг хангах• Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших• Хувийн ариун цэврийг сахих• Суралцах соёл• Хөдөлмөрийн сахилгатай• Нягт нямбай, цэвэрч• Мэргэжилдээ сонирхолтой• Идэвхи санаачлагатай• Хариуцлагатай• Хувийн зохион байгуулалттай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Ажлын төлөвлөгөө гаргах	ГШҮ 1.1 Ажлын талбайд хэмжилт хийх
	ГШҮ 1.2 Ажлын зургийн дагуу хийгдэх заслын ажлын тоо хэмжээг гаргах
	ГШҮ 1.3 Ажлын зургийн дагуу ажил тус бүрийн тоо хэмжээг гаргах
	ГШҮ 1.4 Заслын ажлын хийгдэх хугацааг тооцолох
	ГШҮ 1.5 Заслын ажлыг гүйцэтгэх хүний тоог гаргах
ЧЭ 2. Ажлын багаж хэрэгслийг бэлтгэх	ГШҮ 2.1 Хийгдэх ажилд тохирсон багаж, хэрэгслийг бэлтгэх
	ГШҮ 2.2 Ажилд тохируулан тоног төхөрөмжийг бэлтгэх
	ГШҮ 2.3 Бэлтгэгдсэн багаж хэрэгсэл, тоног төхөрөмжийг шалгах
ЧЭ 3. Шат вандан угсрах	ГШҮ 3.1 Хийгдэх ажлын өндөрт тохируулан шат ванданг бэлтгэх
	ГШҮ 3.2 Шат ванданг ашиглах байрлал руу зөөх
	ГШҮ 3.3 Шат ванданг угсрах
	ГШҮ 3.4 Угсарсан шат ванданг шалгах

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Шавардлагын ажил хийх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Шавардлагын ажил хийх үеийн ХАБЭА-н шаардлага• Шавардлагын ажлын үеийн болон дараах цэвэрлэгээ• Шавардлагын ажилд шаардлагатай материалыг сонгож ашиглах• Барилгын норм ба дүрмийн тухай• Ажил хүлээлцэх• Шавардлагын үеүдийг нэрлэх, тус бүрийн арга ажиллагаа технологийг мэдэх
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Өнгөлгөөний үеийн шавардах аргууд, чанар, зузааныг тодорхойлох• Энгийн тооцоолол хийх• Ажлын зохион байгуулалт хийх• Тусгай хэрэгсэл, хамгаалах хувцасны хэрэглээ• Анхны тусламж үзүүлэх• Энгийн ба сайн чанарын шавардлага хийх• Гадаргууд зуурмагийн тарааж тэгшлэх• Шат, вандан аюулгүй ашиглах• Ажлын зураг уншдаг байх
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Мэргэжилдээ сонирхолтой• Ажлын ачаалал даах чадвартай• Багаар ажиллах чадвартай• Нямбай, цэгцтэй байх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Шавардах гадаргууг бэлтгэх	ГШҮ 1.1 Гадаргуугийн хэвтээ босоо чиглэлийг шалгах
	ГШҮ 1.2 Гадаргууг цэвэрлэх
	ГШҮ 1.3 Өргийн хэсгээс илүү гарсан зуурмагийг цэвэрлэх
ЧЭ 2. Шингэн зуурмаг цацах	ГШҮ 3.1 Бетон хананд цацах шингэн зуурмаганд орох хольцийг бэлтгэх
	ГШҮ 3.2 Шингэн зуурмагийг найруулж бэлтгэх
	ГШҮ 3.3 Найруулсан зуурмагийг цацах
	ГШҮ 3.4 Цацсан гадаргууг шалгах
ЧЭ 3. Шавардлагын зуурмаг бэлтгэх	ГШҮ 4.1 Шавардлагын зуурмагт орох материалыг бэлтгэх
	ГШҮ 4.2 Хуурай хольцийг бэлтгэх
	ГШҮ 4.3 Хуурай хольцыг тогоолох
	ГШҮ 4.4 Тогоонд ус хийх
	ГШҮ 4.5 Тогоог задлах
	ГШҮ 4.6 Зуурмаг зуурах
ЧЭ 4. Шавардлагын зуурмаг цацах	ГШҮ 5.1 Шавардах гадаргууг шалгах
	ГШҮ 5.2 Зуурмагийн тэвшийг бэлтгэх
	ГШҮ 5.3 Шавардлагын зуурмаг бэлтгэх
	ГШҮ 5.4 Зуурмагийг цацах
	ГШҮ 5.5 Зуурмаг цацасныг шалгах
ЧЭ 5. Цацсан шавардлагын зуурмаг тэгшлэх	ГШҮ 6.1 Шавардлагын зуурмагийг босоо чиглэлд тэгшлэх
	ГШҮ 6.2 Зуурмагийг хэвтээ чиглэлд тэгшлэх
	ГШҮ 6.3 Зуурмагыг эргүүлэх хөдөлгөөнөөр тэгшлэх
	ГШҮ 6.4 Гадаргуугийн тэгш эсэхийг шалгах
ЧЭ 6. Амалгаа шавардах	ГШҮ 9.1 Гадаргууг цэвэрлэх
	ГШҮ 9.2 Амалгааны шаврын орцыг бэлтгэх
	ГШҮ 9.3 Шавардах гадаргууг услах
	ГШҮ 9.4 Амалгааны буланг тэгшлэх
	ГШҮ 9.5 Амалгааны гадаргууд шавраар дүүргэлт хийх
	ГШҮ 9.6 Амалгааг шалгах
	ГШҮ 9.7 Амалгааг өнгөлөх
ЧЭ 7. Шавардсан гадаргууг өнгөлөх	ГШҮ 10.1 Өнгөлөх гадаргууг шалгах
	ГШҮ 10.2 Гадаргууг үрж өнгөлөх
	ГШҮ 10.3 Ажлын байрыг цэвэрлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Гадаргууд тэгшилгээ хийх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Гадаргууг бэлтгэж хөрсжүүлэгч хийх технологи• Зуурмаг бэлтгэх технологи• Тэгшилгээ үе буюу хар замаска хийх технологи• Цагаан замаска (шаваас) хийх технологи• Гадаргууг зүлгэх технологи
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Ажлын байрыг бэлтгэх• Хувийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой бүрэн ашиглах• ХАБЭА-н шаардлага, стандартыг ажлын байранд бүрэн ашиглах• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах• Хувийн ариун цэврийг сахих• Замаска хийхийн өмнө гадаргууг бэлтгэх• Хар замаска хийх• Цагаан замаска хийх
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• ХАБЭА-н байдлыг хангах• Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших• Хувийн ариун цэврийг сахих• Суралцах соёл• Хөдөлмөрийн сахилгатай• Нягт нямбай, цэвэрч• Мэргэжилдээ сонирхолтой• Идэвхи санаачлагатай• Хариуцлагатай• Хувийн зохион байгуулалттай• Багаар ажиллах чадвартай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Тэгшлэх гадаргууг бэлтгэх	ГШҮ 1.1 Тэгшилгээ хийх гадаргууг цэвэрлэх
	ГШҮ 1.2 Гадаргууг шалгах
	ГШҮ 1.3 Хагарал болон ан цавыг дүүргэх
	ГШҮ 1.4 Хөрсжүүлэгчийг бэлтгэх
	ГШҮ 1.5 Хөрсжүүлэгчийг гадаргууд түрхэх
	ГШҮ 1.6 Хөрсжүүлэгчийг шалгах
ЧЭ 2. Замаск зуурах	ГШҮ 2.1 Замаск найруулах бэлтгэлийг хангах
	ГШҮ 2.2 Замаскийг зуурах
ЧЭ 3. Хар замаскан тэгшилгээ хийх	ГШҮ 3.1 Гадаргууд хар замаскийг түрхэж жигд татах
	ГШҮ 3.2 Хар замаскан тэгшилгээг шалгах
	ГШҮ 3.3 Хар замаск зүлгэж өнгөлөх
ЧЭ 4. Цагаан замаск 2-3 үе татах	ГШҮ 4.1 Хар замаскадсан гадаргууг шалгах
	ГШҮ 4.2 Цагаан замасканы 1-р үеийг татах
	ГШҮ 4.3 Цагаан замасканы 2-р үеийг татах
	ГШҮ 4.4 Цагаан замасканы 3-р үеийг татах
ЧЭ 5. Замаскадсан гадаргууг зүлгэх	ГШҮ 5.1 Зүлгэх хэсэг рүү гэрэл тусгах
	ГШҮ 5.2 Цагаан замаскний 1-р үеийг зүлгэх
	ГШҮ 5.3 Цагаан замаскний 2 ба 3-р үеийг зүлгэх
	ГШҮ 5.4 Гадаргууд гэрэл барьж жигд байдлыг шалгах
	ГШҮ 5.5 Ажлын байрыг цэвэрлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Бетон шалны ажил хийх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Бетон шал цутгахын өмнө гадаргууг бэлтгэж хөрсжүүлэгчийг түрхэх технологи• Марк маяк тавих технологи• Бетоныг стандарт нормын дагуу зуурах технологи• Зуурсан бетононоос дээжийг зөв авах арга• Бетон шал цутгах технологи• Гадаргууг будалтанд бэлтгэх технологи• Резинэн будагны онцлог• Резинэн будаг хийх технологи
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Ажлын байрыг бэлтгэх• Хувийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой бүрэн ашиглах• ХАБЭА-н шаардлага стандарт ажлын байранд бүрэн ашиглах• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах• Хувийн ариун цэврийг сахих• Бетон шалны ажил хийх• Резинэн будаг хийх
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• ХАБЭА-н байдлыг хангах• Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших• Хувийн ариун цэврийг сахих• Суралцах соёл• Хөдөлмөрийн сахилгатай• Нягт нямбай, цэвэрч• Мэргэжилдээ сонирхолтой• Идэвхи санаачлагатай• Хариуцлагатай• Хувийн зохион байгуулалттай• Багаар ажиллах чадвартай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Шалны гадаргууг бэлтгэх	ГШҮ 1.1 Шал цутгах хучилтын хавтангийн гадаргууг шалгах
	ГШҮ 1.2 Бетон шал цутгах гадаргууг цэвэрлэх
	ГШҮ 1.3 Хөрсжүүлэгчийг түрхэх
	ГШҮ 1.4 Ус чийгний хамгаалалт хийх
	ГШҮ 1.5 Дуу чимээ тусгаарлагч хийх
ЧЭ 2. Шалны маяк тавих	ГШҮ 2.1 Түвшин хэмжих багажийг байрлуулах
	ГШҮ 2.2 Шал цутгах талбайд сантехникийн шугам хоолой байгаа эсэхийг нягтлах
	ГШҮ 2.3 Суурь түвшинг тогтоох
	ГШҮ 2.4 Маякны түвшинг гаргах
	ГШҮ 2.5 Маякны шнур утас татах
	ГШҮ 2.6 Маякны зуурмаг зуурах
	ГШҮ 2.7 Шнур утасны дагуу маяк хийх
	ГШҮ 2.8 Хийсэн маякны тэгш байдлыг шалгах
ЧЭ 3. Шалны бетон зуурмаг бэлтгэх	ГШҮ 3.1 Шалны бетон зуурмагийн орцыг бэлтгэх
	ГШҮ 3.2 Шалны бетон зуурмаг зуурах
ЧЭ 4. Бетон шал цутгах	ГШҮ 4.1 Шалны бетон зуурмагийг асгах
	ГШҮ 4.2 Шалны бетон зуурмагыг тэгшлэх
	ГШҮ 4.3 Бетон шалыг өнгөлөх
ЧЭ 5. Резинэн будгийн талбайг бэлтгэх	ГШҮ 5.1 Резинэн будаг хийх бетон шал бүрэн хатсаныг шалгах
	ГШҮ 5.2 Бетон шалны гадаргууг шалгах
	ГШҮ 5.3 Бетоны ан цав, хялгасан хагарлыг нөхөх
	ГШҮ 5.4 Шал тэгшлэгчээр өнгөлөх
	ГШҮ 5.5 Бетон гадаргууны тоос шороог цэвэрлэх
ЧЭ 6. Шалны хөрсжүүлэгч түрхэх	ГШҮ 6.1 Резинэн будгийн хөрсжүүлэгчийг сонгох
	ГШҮ 6.2 Хөрсжүүлэгчийн заавартай танилцаж холих харьцааг тогтоох
	ГШҮ 6.3 Хөрсжүүлэгчийн тогтоосон хэмжээгээр найруулах
	ГШҮ 6.4 Хөрсжүүлэгчийг гадаргууд түрхэх
	ГШҮ 6.5 Хөрсжүүлэгчийг бүрэн түрхэгдсэн эсэхийг шалгах
	ГШҮ 6.6 Хөрсжүүлэгчийг дутуу түрхсэн хэсэгт дахин давхарлаж түрхэх
ЧЭ 7. Шалны резинэн будаг хийх	ГШҮ 7.1 Резинэн будгийн холих харьцааг тогтоох
	ГШҮ 7.2 Резинэн будгийн хэрэглэх хэмжээг тогтоох
	ГШҮ 7.3 Резинэн будгийг найруулах
	ГШҮ 7.4 Резинэн будгийн түрхэх
	ГШҮ 7.5 Резинэн будгийн бүрэн түрхэгдсэн эсэхийг шалгах
	ГШҮ 7.6 Ажлын талбайг цэвэрлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Будгийн ажил хийх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Будгийн ажлын өмнө гадаргууг бэлтгэх, шалгах• Хөрсжүүлэгч хийх (түрхэх) технологи• Өнгө үүсгэх (гаргах)• Будаг найруулах технологи• Будаг хийх технологи• Будгийн хамгаалалтын үе хийх технологи
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Ажлын байрыг бэлтгэх• Хувийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой бүрэн ашиглах• ХАБЭА-н шаардлага, стандартыг ажлын байранд бүрэн ашиглах• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах• Хувийн ариун цэврийг сахих• Будгийн ажил эхлэхийн өмнө гадаргууг шалгаж, бэлтгэх• Усан болон усгүй будаг хийх• Хамгаалалтын үе хийх
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• ХАБЭА-н байдлыг хангах• Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших• Хувийн ариун цэврийг сахих• Суралцах соёл• Хөдөлмөрийн сахилгатай• Нягт нямбай, цэвэрч• Мэргэжилдээ сонирхолтой• Идэвхи санаачлагатай• Хариуцлагатай• Хувийн зохион байгуулалттай• Багаар ажиллах чадвартай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Будгийн гадаргууг бэлтгэх	ГШҮ 1.1 Будах гадаргууг цэвэрлэх
	ГШҮ 1.2 Будах гадаргууг шалгах
	ГШҮ 1.3 Хөрсжүүлэгчийг бэлтгэх
	ГШҮ 1.4 Будах гадаргууд хөрсжүүлэлт хийх
ЧЭ 2. Будгийн өнгө гаргах	ГШҮ 2.1 Өнгө оруулагчийн тоо ба өнгийг тодруулах
	ГШҮ 2.2 Өнгө оруулагчийг шалгах
	ГШҮ 2.3 Өнгө оруулагчийн хэмжээг тогтоох
	ГШҮ 2.4 Будгийн өнгийг шалгах
ЧЭ 3. Тосон болон усан будаг найруулах	ГШҮ 3.1 Суурь будгийг шингэлэх
	ГШҮ 3.2 Шингэлсэн будгийг шалгах
ЧЭ 4. Гадаргууд будаг хийх	ГШҮ 4.1 Хамгаалалтын цаас наах
	ГШҮ 4.2 Тааз будах
	ГШҮ 4.3 Булан ирмэгийг будах
	ГШҮ 4.4 Хана будах
	ГШҮ 4.5 Зориулалтын цаасан наалтыг хуулах
ЧЭ 5. Бэхжүүлэгч түрхлэг хийх	ГШҮ 5.1 Бэхжүүлэгч түрхлэгийг бэлтгэх
	ГШҮ 5.2 Булан ирмэгийг бэхжүүлэгчээр будах
	ГШҮ 5.3 Гадаргууд бэхжүүлэгч түрхлэг хийх
	ГШҮ 5.4 Зориулалтын цаасан наалтыг хуулах
	ГШҮ 5.5 Ажлын байрыг цэвэрлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Цаасан өнгөлгөөний ажил хийх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Цаасан өнгөлгөөний ажил хийх үеийн ХАБЭА-н шаардлага• Цаасан өнгөлгөөний ажилд шаардлагатай материалыг сонгож ашиглах• Цаасан өнгөлгөөний ажлын үеийн цэвэрлэгээ• Барилгын норм ба дүрмийн тухай• Ажил хүлээлцэх• Цаас наах гадаргууд эмжээр шугам татах, өнгөний чанар, цаасны төрлийн талаар
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Энгийн тооцоолол хийх• Ажлын зохион байгуулалт хийх• Тусгай хэрэгсэл, хамгаалах хувцасны хэрэглээ• Анхны тусламж үзүүлэх• Ажлын зураг уншдаг байх• Шат, вандан аюулгүй ашиглах• Гадаргуугийн төрлөөс хамаарч цавууг жигд түрхэх технологи• Хулдаасан төрлийн цаас наах технологи• Цавуутай цаасыг агаарын цэврүү үүсгэхгүй жигд даралтаар дарах технологи
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Мэргэжилдээ сонирхолтой• Ажлын ачаалал даах чадвартай• Багаар ажиллах чадвартай• Нямбай, цэгцтэй байх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Цаасан өнгөлгөөний ажилд гадаргууг бэлтгэх	ГШҮ 1.1 Цаасан өнгөлгөө хийх гадаргууг цэвэрлэх
	ГШҮ 1.2 Ажлын байрыг цэвэрлэх
ЧЭ 2. Цаасан өнгөлгөөг зүсэх	ГШҮ 2.1 Цаасан өнгөлгөө хийх гадаргууг хэмжих
	ГШҮ 2.2 Цаасан өнгөлгөөний ирмэгийг шалгах
	ГШҮ 2.3 Цаасан өнгөлгөөг нугалж бэлтгэх
	ГШҮ 2.4 Цаасан өнгөлгөөг нугалсны дагуу зүсэх
ЧЭ 3. Цаасан өнгөлгөөний эхлэх тэгш хэмийг тогтоох	ГШҮ 3.1 Цаасан өнгөлгөө наах эхний цэгийг тогтоох
	ГШҮ 3.2 Эхлэх цэгт босоо шугамыг татах
	ГШҮ 3.3 Цаасан өнгөлгөөний дээд ирмэгийн хэмжээг тавих
ЧЭ 4. Цаасан өнгөлгөөний цавууг найруулах	ГШҮ 4.1 Цаасан өнгөлгөөний цавууг сонгох
	ГШҮ 4.2 Цавууг найруулах
	ГШҮ 4.3 Цавууг шалгах
ЧЭ 5. Цаасан өнгөлгөөг цавуудах	ГШҮ 5.1 Цаасыг цавуудахад бэлтгэх
	ГШҮ 5.2 Бэлтгэсэн цаасанд цавууг жигд түрхэх
	ГШҮ 5.3 Цавуудсан цаасан өнгөлгөөг нугалах
ЧЭ 6. Цаасан өнгөлгөөг наах	ГШҮ 6.1 Цаасан өнгөлгөө наах гадаргууг цавуудах
	ГШҮ 6.2 Цаасан өнгөлгөөг гадаргууд нааж эхлэх
	ГШҮ 6.3 Цаасан өнгөлгөөний наалтыг эцэслэх
	ГШҮ 6.4 Цаасны дээд ирмэгийг зүсэх
	ГШҮ 6.5 Цаасан өнгөлгөөний наалтыг шалгах
	ГШҮ 6.6 Ажлын байрыг цэвэрлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Гоёлын хийцийн ажил хийх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журам, практик хэрэглээ• Хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, тэдгээрийн ашиглалт• ХАБЭА-н шаардлага, стандартыг мөрдөх• Гоёлын хийцийн ажил гүйцэтгэх төрлүүд• Гоёлын хийцийн материалуудыг таних• Гоёлын хийцийн хийх технологи• Гоёлын хийцийн ажлын зураг унших• Гоёлын хийцийг бэхлэх, тогтоох аргуудын талаар мэдэх
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Хувийн ариун цэврийг сахих• Аюул, эрсдэлийг тодорхойлж, хянах• Бусадтай харилцах• Ажлын байрыг бэлтгэх• Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах• Талбайн зохион байгуулалт• Материалыг сонгож ашиглах• Гадаргууд тохируулан бэлтгэх• Гоёлын хийцийг тогтоох бэхлэх• Гоёлын хийц эдлэлийг будах, өнгөлөх• Гоёлын хийцийн засвар үйлчилгээ хийх
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Аюулгүй байдлыг хангах• Эрүүл ахуйг хангах• Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших• Хувийн ариун цэврийг сахих• Суралцах соёл.• Хөдөлмөрийн сахилгатай• Нягт нямбай, цэвэрч• Мэргэжилдээ сонирхолтой• Идэвхи санаачлагатай• Хариуцлагатай• Хувийн зохион байгуулалттай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Гоёлын хийц тогтоох технологийг сонгох	ГШҮ 1.1 Гоёлын хийцийн төрлийг тодорхойлох
	ГШҮ 1.2 Гоёлын хийцийн байршлыг тогтоох
	ГШҮ 1.3 Бэхлэх гадаргууг тодорхойлох
	ГШҮ 1.4 Гоёлын хийцийг тогтоох бэхэлгээг сонгох
ЧЭ 2. Хэмжилтийн тэмдэглэгээ тавих	ГШҮ 2.1 Гоёлын хийцийн байршлын тэмдэглэгээг тавих
	ГШҮ 2.2 Гоёлын хийцийн тоо, хэмжээг тогтоох
	ГШҮ 2.3 Бэхэлгээний ажлын эхлэх цэгийг тэмдэглэх
